

Гүйцэтгэх захирлын 2015 оны
сарын-ны өдрийн/дугаар,
дүгээр/ тушаалын хавсралт

Мэргэжлийн шалгалтын комиссын
үйл ажиллагааны журам

Энэ журмаар холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд ажиллагсдаас мэргэжлийн анхан шатны, ээлжит, ээлжит бус болон мэргэжлийн зэрэг олгох шалгалт авахтай холбоотой харилцааг зохицуулна.

Нэг. Мэргэжлийн шалгалтын комиссын эрх, үүрэг

1.1. Шалгалтыг мэргэжлийн шалгалтын комисс зохион байгуулна.

1.2. Мэргэжлийн шалгалтын комисс нь шинээр ажилд орж байгаа болон ажлын байр өөрчлөгдсөн ажилтны анхан шатны шалгалтыг тухайн албан тушаалд томилогдсоноос хойш, тогтоосон хугацаанд авах бөгөөд холбогдох материал, шалгалтын үнэлгээнээс хамааруулан бие даан ажиллуулах эсэхийг захирлын зөвлөлд танилцуулна.

1.3. Мэргэжлийн шалгалтын асуултыг албан тушаалын эрх, үүрэг, үйл ажиллагааны чиглэл, ажил үүргийн хуваарь, зайлшгүй мэдвэл зохих эрх зүйн акт, ажлын байрны тодорхойлолтод нийцүүлэн боловсруулж, шалгалт өгөхөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө ажилтан шалгалтын сэдэв, хуваарийг танилцуулна.

1.4. Цахилгаан тоноглолд үйлчилдэг ажилтны мэдлэг, мэргэжлийн зэрэг ахиулах шалгалтад мэргэжлийн байгууллагаас хөндлөнгийн ажилтныг байлцуулна.

1.5. Шалгалт өгөх ажилтан нь батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдсан эсэхийг нягтлаж, шалгалт авна.

1.6. Шалгалтыг амаар, бичгээр, компьютер ашиглан эсвэл тэдгээрийг хосолсон хэлбэрээр авна.

1.7. Комисс нь шалгалтын дүнг нэгтгэн гаргаж, Захирлын зөвлөлд танилцуулна.

Хоёр. Нэгжийн дарга нарын эрх, үүрэг

2.1. Хөтөлбөрийн дагуу ажилтан бүрийг сургалтад хамруулах үүрэгтэй.

2.2. Шинээр ажилд орсон болон ажлын байр өөрчлөгдсөн, ажилтныг хөтөлбөрийн дагуу сургаж, холбогдох материалыг бүрдүүлэн Мэргэжлийн шалгалтын комисст өгнө.

2.3. Нэгжийн дарга нар мэргэжлийн зэрэг олгох /ахиулах/ ажилчдыг сонгон, Мэргэжлийн шалгалтын комиссын даргаар батлуулна.

Гурав. Мэргэжлийн шалгалт авах хугацаа

3.1. Ажилтнаас мэргэжлийн анхны шатны шалгалтыг Гүйцэтгэх захирлын тушаалд заасан хугацаанд авна.

3.2. Мэргэжлийн шалгалтын комисс нь ажиллагсдаас мэргэжлийн ээлжит шалгалтыг жил бүрийн 04 дүгээр сард багтаан авна.

3.3. Ээлжит бус болон мэргэжлийн зэрэг олгох шалгалтын эзлэхүүн, хугацааг дүрмийн шаардлагад нийцүүлж мөн түүнчлэн осол гэмтэл, техникийн зөрчилтэй холбогдуулан Мэргэжлийн шалгалтын комиссын дарга тогтооно.

Дөрөв. Шалгалтын сэдэв, хугацаа, үнэлгээ

4.1. Шалгалтыг компьютер ашиглан тестээр авах бөгөөд 45 асуултыг 8 минутад бөглүүлнэ.

Сэдвийн бүлэглэл	Аюулгүй ажиллагааны дүрэм	Техник ашиглалтын дүрэм	Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм	Анхны тусламж үзүүлэх дүрэм	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй тухай
Асуултын тоо	20	10	5	5	5
Хугацаа /минут, сек/	2 минут 45 сек	2 минут 15 сек	1 минут	1 минут	1 минут
Үнэлгээ /оноогоор/	0-100	0-100	0-100	0-100	0-100

4.2. 80-100 оноо авбал хангалттай, 0-75 оноо авбал хангалтгүй үнэлгээ авсан гэж үзнэ.

4.3. Шалгалтын үнэлгээг шалгалтын комиссын тогтоол болон журналд тусгаж, мэргэжлийн үнэмлэхэд бичнэ.

4.4. Мэргэжлийн шалгалтын комиссын гишүүд болон шалгуулсан ажилтан шалгалтын комиссын тогтоолтой танилцаж, гарын үсэг зурснаар үнэлгээг баталгаажсан гэж үзнэ.

Тав. Хариуцлага

5.1. Мэргэжлийн шалгалтад хангалтгүй үнэлгээ авсан ажилтан шалгалт өгснөөс хойш 7-20 хоногийн дотор давтан шалгалт /хангалтгүй үнэлгээ авсан бүлгээр/ өгөх бөгөөд 2 дахь шалгалтад тэнцээгүй тохиолдолд сарын үр дүнгээр олгох шагнал цалинг тодорхой хувиар бууруулан олгох тухай шийдвэрийг Эдийн засаг, санхүүгийн албанд хүргүүлэх ба 3 дахь шалгалтад тэнцээгүй ажилтны хөдөлмөрийн гэрээг үргэлжлүүлэх эсэх асуудлыг шалгалтын комиссын шийдвэрийг үндэслэн ажил олгогч зохих хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

5.2. Мэргэжлийн шалгалтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр, тогтоосон хугацаанд өгөөгүй ажилтныг хангалтгүй үнэлгээ авсанд тооцно.

